



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/75/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Булганчимэг Утас: 51-261885 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД
БОЛОВСРОЛ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Д.НАМСРАЙ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/319
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн Урьдчилж гарсан зардал дансны эцсийн үлдэгдэлд 13,994,855.0 мянган төгрөгийн сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийн зардлыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан зөрчил нь тогтоосон 112,275.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн Газар болон Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага хооронд 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээний дагуу Инженер, технологийн дээд боловсрол төслийн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Төсөл хэрэгжих хугацаанд оюутнуудыг сургуульд нь хүргэж өгөх, гадаадын багш авах, оюутнуудын тоо төлөвлөсөн тоондоо хүрээгүй, Ковид-19 цар тахлын үед худалдан авах ажиллагааны зардал хэмнэгдсэн шалтгаануудын улмаас 1.2 тэрбум иен буюу 27,600,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр зарцуулагдаагүй байна. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /ЖАЙКА/-аас хөнгөлөлттэй зээлийн үлдэгдлийг бүрэн ашиглах боломжийг санал болгосны дагуу Боловсрол Шинжлэх Ухааны Яамнаас төслийн хэрэгжих хугацааг сунгах хүсэлт тавьж 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр шинэчилсэн “Санамж бичиг”-т талууд гарын үсэг зурж баталгаажуулан, 2027 оны 6 дугаар сар хүртэл сунгасан байна.

Дээрх санхүүжилтийн үлдэгдлийн 20,918,500.0 мянган төгрөгийг худалдан авалт, 6,681,500.0 мянган төгрөгийг хүний нөөцийг хөгжүүлэх зардалд төсөвлөн 2024 оны төлөвлөгөөнд тусган Төслийн удирдах хороогоор батлуулсан байна.

Аудитын гол асуудал

Зээлийн хэлэлцээрийн дагуу төслийн нийт хугацаанд үйл ажиллагааны баталсан төлөвлөгөөний дагуу нийт 5 бүрэлдэхүүн хэсгийн 9 бүлэг ажлын гүйцэтгэлд 133,789,777.0 мянган төгрөг зарцуулж, 94.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Японы Улсын их сургууль, Коосэн төгссөн болон сурч байгаа нийт 606 оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийн зардалд 66,209,286.9 мянган төгрөгийг зарцуулаад байна. Үүнээс суралцагчдын амьжиргааны зардал нийт 39,090,360.7 мянган төгрөг, бэлнээр олгосон 1,737,344.5 мянган төгрөг байна. Зээлийн гэрээнд амьжиргааны зардлыг яаж олгохыг тусгаагүй, тусгайлан боловсруулсан журам баталж мөрдөөгүй байна.

Суралцагчид төгсөж ирээд Монгол Улсад мэргэжлээрээ 5 жил ажиллаж, гэрээний үүргийг хангасны дараа сургалтын санхүүжилт нь БШУС-ын тушаал гарч тэтгэлэгт хамрагдана. Төслийн нийт хугацаанд 1 доктор, 1 магистрын оюутны сургалтын зардал 138,733.5 мянган төгрөг тэтгэлэг болж зээлээс чөлөөлөгдсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,273,177,272.14	69,628,413,408.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,096,808,837.60	3,418,731,709.18
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	125,996.31	-
31120	Гадаад валют	125,996.31	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,096,682,841.29	3,418,731,709.18
3121	Төгрөг	-	-
31210	Төрийн сангийн харилцах	-	-
3122	Гадаад валют	6,096,682,841.29	3,418,731,709.18
31222	Монгол банкин дахь харилцах	5,069,067,116.43	2,359,564,134.40
31223	Арилжааны банкин дахь харилцах	1,027,615,724.86	1,059,167,574.78
33	АВЛАГА	184,564,781.97	-
33100	Ажиллагсадтай холбоотой авлага	1.06	-
33510	Байгууллагаас авах авлага	184,564,780.91	-
34	УРЬДЧИЛГАА	60,161,842,960.18	66,209,286,899.58
34600	Урьдчилж гарсан зардал	60,161,842,960.18	66,209,286,899.58
35	БАРАА МАТЕРИАЛ	2,829,960,692.39	394,800.00
354	Хангамжийн материал	2,829,960,692.39	394,800.00
35420	Аж ахуйн материал	90,000.00	90,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,829,870,692.39	304,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,284,811.86	812,436.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,284,811.86	812,436.14
392	Биет хөрөнгө	4,228,181.59	812,436.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,893,476.34	25,513,476.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,084,113.02)	(24,972,040.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,982,890.95	15,492,990.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,564,072.68)	(15,221,990.84)
393	Биет бус хөрөнгө	56,630.27	-
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(713,369.73)	(770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	69,277,462,084.00	69,629,225,844.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,615,020,568.95	183,900,311.97
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,615,020,568.95	183,900,311.97
41361	Байгууллагад төлөх өглөг	1,615,020,568.95	183,900,311.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	67,662,441,515.05	69,445,325,532.93
51	Засгийн газрын хувь оролцоо	67,662,441,515.05	69,445,325,532.93
512	Хуримтлагдсан үр дүн	67,662,441,515.05	69,445,325,532.93
51210	Өмнөх үеийн үр дүн	69,701,801,770.41	67,662,441,515.05
51220	Тайлант үеийн үр дүн	(2,039,360,255.36)	1,782,884,017.88
5	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	69,277,462,084.00	69,629,225,844.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	17,909,322,769.01	9,592,261,100.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,367,360,769.01	9,129,066,800.60
120	Нийтлэг татварын бус орлого	17,367,360,769.01	9,129,066,800.60
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	17,367,360,769.01	9,129,066,800.60
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	541,962,000.00	463,194,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	541,962,000.00	463,194,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	20,126,295,559.47	7,525,144,611.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,042,241,907.19	2,830,149,554.08
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,936,284,869.25	2,822,757,237.50
210101	Үндсэн цалин	344,496,162.36	325,804,522.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	43,062,021.59	40,725,564.42
2103	Байр ашиглалтын тогтмол зардал	2,700,000.00	3,150,000.00
210304	Байрны түрээсийн зардал	2,700,000.00	3,150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,946,727.00	11,138,640.00
210401	Бичиг хэргийн зардал	6,697,776.00	3,224,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	5,040,000.00	6,200,000.00
210404	Ном хэвлэлийн зардал	-	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,208,951.00	1,314,640.00
2107	Томилолт зочны зардал	232,000.00	51,248,676.00
210701	Гадаад томилолт	-	51,149,676.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	232,000.00	99,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	2,522,198,966.02	2,381,917,559.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	2,522,198,966.02	2,381,917,559.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,648,992.28	8,772,275.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,299,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	10,648,992.28	3,472,375.72
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,084,053,652.28	4,694,995,057.84
223001	Шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	17,084,053,652.28	4,694,995,057.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,957,037.94	7,392,316.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,957,037.94	7,392,316.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(2,216,972,790.46)	2,067,116,488.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО (VI)	1,291,027,697.94	1,186,843,497.55
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,291,027,697.94	1,186,843,497.55
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ (V)	1,113,415,162.84	1,471,075,968.35
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	1,113,415,162.84	1,471,075,968.35
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(2,039,360,255.36)	1,782,884,017.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	12,792,318,544.00	5,002,138,362.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,250,356,544.00	4,538,944,062.00
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,250,356,544.00	4,538,944,062.00
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	12,250,356,544.00	4,538,944,062.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	541,962,000.00	463,194,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	541,962,000.00	463,194,300.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	10,120,391,147.63	7,440,555,810.87
21	Бараа, ажил үйлчилгээний зардал	10,014,434,109.69	7,433,163,494.29
210101	Үндсэн цалин	344,496,162.36	323,120,704.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	43,062,021.59	40,415,000.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,700,000.00	3,150,000.00
210304	Байрны түрээсийн зардал	2,700,000.00	3,150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,946,727.00	9,938,640.00
210401	Бичиг хэргийн зардал	6,697,776.00	3,224,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	5,040,000.00	5,000,000.00
210404	Ном хэвлэлийн зардал	-	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,208,951.00	1,314,640.00
2107	Томилолт, зочны зардал	232,000.00	51,248,676.00
210701	Гадаад албан томилолт	-	51,149,676.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	232,000.00	99,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	9,610,997,198.74	6,997,306,755.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	9,610,997,198.74	6,997,306,755.87
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	-	7,983,718.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,983,718.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,957,037.94	7,392,316.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,957,037.94	7,392,316.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,671,927,396.37	(2,438,417,448.87)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
6	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,291,027,697.94	1,180,896,424.12
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	1,113,415,162.84	1,420,556,103.67
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	177,612,535.10	(239,659,679.55)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,849,539,931.47	(2,678,077,128.42)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,247,268,906.13	6,096,808,837.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,096,808,837.60	3,418,731,709.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	69,701,801,770.41	69,701,801,770.41
Тайлант үеийн үр дүн	-	(2,039,360,255.36)	(2,039,360,255.36)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	67,662,441,515.05	67,662,441,515.05
Тайлант үеийн үр дүн	-	1,782,884,017.88	1,782,884,017.88
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	69,445,325,532.93	69,445,325,532.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,119,894,300.00	12,023,286,232.89	96,608,067.11	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,963,194,300.00	8,866,702,550.12	96,491,749.88	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,963,194,300.00	8,866,702,550.12	96,491,749.88	99.2
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,825,000.00	323,120,704.00	704,296.00	99.8
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,500,000.00	40,415,000.42	84,999.58	99.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,150,000.00	3,150,000.00	-	-
210303	Байрны түрээс	3,150,000.00	3,150,000.00	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	10,616,000.00	9,938,640.00	677,360.0	93.6
210401	Бичиг хэрэг	3,294,000.00	3,224,000.00	70,000.0	97.9
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	5,000,000.00	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450,000.00	-	450,000.0	0.0
210404	Ном, хэвлэл	400,000.00	400,000.00	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,472,000.00	1,314,640.00	157,360.0	89.3
2107	Томилолт, зочны зардал	56,903,300.00	51,248,676.00	5,654,624.00	90.0
210701	Гадаад албан томилолт	56,543,300.00	51,149,676.00	5,393,624.00	90.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	360,000.00	99,000.00	261,000.00	27.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,520,000,000.00	8,430,845,811.70	89,154,188.30	98.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,520,000,000.00	8,430,845,811.70	89,154,188.30	98.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,200,000.00	7,983,718.00	216,282.00	97.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,200,000.00	7,983,718.00	216,282.00	97.3
222	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,156,700,000.0	3,156,583,682.77	116,317.23	100.0
222001	Тоног төхөөрөмж	3,156,700,000.0	3,156,583,682.77	116,317.23	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,119,894,300.00	9,584,868,784.02	2,535,025,515.98	79.1
120	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	11,656,700,000.00	9,129,066,800.60	2,527,633,199.40	78.3
120044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	11,656,700,000.00	9,129,066,800.60	2,527,633,199.40	78.3
13	Улсын төсвөөс санхүүжих	463,194,300.00	455,801,983.42	7,392,316.58	98.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	463,194,300.00	455,801,983.42	7,392,316.58	98.4
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,096,808,837.60		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,418,731,709.18		
5	Тохируулгын дүн		(239,659,679.55)		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	9	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11	8	-	100.0

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13,994,855.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэн нь өмнөх аудитаар давтан гаргахгүй албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй байх тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 13,994,855.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 122,275.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
				Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Урьдчилж гарсан зардал дансны эцсийн үлдэгдэлд тооцоо нийлсэн акт үйлдээгүй 13,994,855.0 мянган төгрөг	1	13,994,855.0	-	-	-	-	1	1
Дүн		1	13,994,855.0	-	-	-	-	1	1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:				
			Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Төсөл нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 166 мэдээллээс 153 мэдээлэл хугацаанд нь байршуулж, Аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт, түүний шалтгаан тайлбар зэрэг 13 мэдээг хугацаа хоцроосон нь 81.0 хувийн гүйцэтгэлтэй байна.	1	9,592,261.0	1	9,592,261.0			
Дүн	1	9,592,261.0	1	9,592,261.0			